

2018 оны III улирал

НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2018
оны III улирлын санхүүгийн тайлангийн
нэгтгэлийн танилцуулга

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага
тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

Агуулга

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	1
1.1 Ерөнхий төлөв байдал	1
1.2 Статистик үзүүлэлтүүд	2
2. АКТИВЫН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт	6
2.2 Зээл.....	8
2.2.1 Зээлийн зориулалт	8
2.2.2 Зээлийн багцын чанар	9
2.2.3 Зээлдэгчид	10
2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	10
3. ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ	11
3.1 Өр төлбөр.....	11
3.2 Өөрийн хөрөнгө	14
3.3 Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт.....	15
4. ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	16
4.1 Орлого.....	16
4.2 Зарлага	17
4.3 Ашигт ажиллагаа	17
5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	18
5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	19
6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД	21
6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд	21
6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд.....	22
6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд	23
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ	25
ДҮГНЭЛТ.....	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл.....	1
Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо.....	1
Хүснэгт 5 Харилцагчид.....	2
Хүснэгт 6 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/.....	3
Хүснэгт 7 ББСБ-уудын тархалт /хот/.....	1
Хүснэгт 8 ББСБ-уудын тархалт /орон нутаг, бүсээр/.....	1
Хүснэгт 9 Активын бүтэц /сая төгрөгөөр/.....	6
Хүснэгт 10 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/.....	6
Хүснэгт 11 Авлага /тэрбум төгрөгөөр/.....	8
Хүснэгт 12 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	8
Хүснэгт 13 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/.....	9
Хүснэгт 14 Ерөнхий статистик /харилцагчид/.....	10
Хүснэгт 15 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/.....	11
Хүснэгт 16 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 17 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/.....	13
Хүснэгт 20 Бусад пассив /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 21 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Улаанбаатар хот/.....	15
Хүснэгт 22 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сум/.....	15
Хүснэгт 23 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Бусад аймаг, сумдад/.....	15
Хүснэгт 24 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая төгрөгөөр/.....	17
Хүснэгт 25 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	17
Хүснэгт 26 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ.....	18
Хүснэгт 27 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ.....	18
Хүснэгт 28 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ.....	19
Хүснэгт 29 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/.....	21
Хүснэгт 30 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц.....	22
Хүснэгт 31 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц.....	22
Хүснэгт 32 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/.....	22
Хүснэгт 33 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив.....	23
Хүснэгт 34 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/.....	24
Хүснэгт 35 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 36 Орлогын бүтэц /мянган төгрөгөөр/.....	24

Зургийн жагсаалт

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо.....	1
Зураг 2 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо.....	2
Зураг 3 Санхүүгийн програм ашиглалт.....	3
Зураг 4 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт.....	1
Зураг 5 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /сүүлийн 5 жилээр/.....	7
Зураг 6 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/.....	7
Зураг 7 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	7
Зураг 8 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	8


Зураг 9 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/	8
Зураг 10 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/.....	9
Зураг 11 Зээлийн чанар (нийт зээлд эзлэх хувь).....	9
Зураг 12 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа	9
Зураг 13 Зээлдэгчдийн боловсрол	10
Зураг 14 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	10
Зураг 15 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	11
Зураг 16 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Зураг 17 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 18 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг /сая төгрөгөөр/.....	14
Зураг 19 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	14
Зураг 20 Ашигт ажиллагааны үзүүлэлт.....	16
Зураг 21 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/	16
Зураг 22 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/.....	16
Зураг 23 Үндсэн бус үйл ажиллагааны орлого	17
Зураг 24 Ашигийн өсөлт /хувиар/.....	17
Зураг 25 Зохистой харьцаа	18
Зураг 26 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт	21
Зураг 27 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	22
Зураг 28 Хүүгийн бус зардлын бүтэц.....	24

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Ерөнхий төлөв байдал

2018 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 540 ББСБ байна. Энэ нь 2017 оны III улирлаас 5 ББСБ буюу 0.9%, оны эцсээс 6 ББСБ буюу 1.1 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



2018 оны III улирлын байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ байгаа бол хөдөө орон нутагт 76 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 оны III улиралд Хорооны хуралдаанаар 13 асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 3 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох;
- 2 ББСБ-д 2 төрлийн тусгай зөвшөөрөл нэмж олгох;
- 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох;
- 2 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь түдгэлзүүлэх;
- 4 ББСБ-ын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сэргээх.

2018 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбартай холбоотой Хорооны даргын 371 /III улиралд 56/

тушаал гарчээ. Үүнээс 336 /III улиралд 43/ тушаалаар 304 ББСБ /29 ББСБ 2 удаа, 1 ББСБ 4 удаа өөрчлөлт оруулсан/ 112.6 тэрбум төгрөгөөр /III улиралд 14.6 тэрбум төгрөг/ хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж, 9 ББСБ оноосон нэрээ өөрчилсөн бол 18 ББСБ 44 /III улиралд 9 ББСБ 16/ салбар нээж, 1 ББСБ-ын 2 салбар хаах асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

	2014 III	2015 III	2016 III	2017 III	2018 III
Шинээр олгосон	120	80	63	9	13
Хүчингүй	5	8	4	7	7
Түтгэлзүүлсэн	5	6	0	1	17
Сэргээсэн	1	5	1	8	7
Нийт ББСБ	378	450	509	535	540

Үйл ажиллагааны төрөл

2018 оны III улиралд шинээр банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 3 ББСБ авсан бөгөөд, үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд /гадаад валют арилжаа, факторинг/ 2 тусгай зөвшөөрөл нэмж авсан байна.

Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2017 III	2018 III	тоо	хувь
	Нийт ББСБ	535	540	5	0.9%
1	Зээл	482	491	9	1.9%
<i>Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>					
2	Факторингийн үйлчилгээ	22	21	-1	-4.5%
3	Төлбөрийн баталгаа гаргах	16	18	2	12.5%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2	3	1	50.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	15	23	8	53.3%
6	Гадаад валютын арилжаа	147	153	6	4.1%
<i>Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>					
7	Итгэлцлийн үйлчилгээ	27	29	2	7.4%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	6	9	3	50.0%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	31	31	0	0.0%


1.2 Статистик үзүүлэлтүүд

2018 оны III улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 540 ББСБ-аас 97.0% буюу 524 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд дор дурдсан нэр бүхий 16 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2018 оны III улирлын байдлаар 540 ББСБ 9 төрлийн 778 тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын 90.9% буюу 491 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 65.9% буюу 356 ББСБ дагнан эрхэлж байгаа бол 28.3% буюу 153 ББСБ гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 8.5% буюу 46 ББСБ дагнан эрхэлж байна.

2018 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 4766 хувь нийлүүлэгчдийн 540 ББСБ, 206 салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2652 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,510,982 харилцагчдад хүрч үйлчилж байна.

Зураг 2 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо



• Харилцагчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсч 1,5 саяд хүрлээ. Тэдгээрийн 48.6% нь эмэгтэй, 51.2% нь

эрэгтэй, 0.2% нь хуулийн этгээд байна. 83.1 хувийг 2 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна.

Хүснэгт 3 Харилцагчид

	ББСБ тоо	Хувь	Харилцагчдийн тоо	Хувь
100-аас доош	349	64.6%	12,301	0.8%
100-1000	152	28.1%	43,166	2.9%
1001-10,000	31	5.7%	102,049	6.8%
10,000-1,000,000	7	1.3%	169,368	11.2%
1,000,000-аас дээш	1	0.2%	1,184,098	78.4%
НИЙТ	540	100.0%	1,510,982	100.0%

• Хувьцаа эзэмшигчид

2018 оны III улирлын байдлаар 540 ББСБ-ын 4766 хувьцаа эзэмшигч байна. 1 ББСБ 25 хувиа нийтэд санал болгож хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болсонтой холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн тоо 4.6 дахин өсжээ. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийг оролцуулалгүйгээр 1052 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байгаа ба энэ нь өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

Нийт 540 ББСБ-ын 298 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 236 ББСБ нь 2-9, 6 ББСБ нь 10-аас дээш хувьцаа эзэмшигчтэй байна. Хувьцаат компанийг оролцуулалгүйгээр хамгийн олон нь 36 хувьцаа эзэмшигчтэй ББСБ байна.

• Ажиллагсад

540 ББСБ-д 2652 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 15.9 хувь буюу 363 ажилтнаар оны эхнээс 7.2 хувь буюу 179 ажилтнаар нэмэгдсэн дүн юм. Нийт ажилчдын 55.5% буюу 1472 нь эмэгтэй, 44.5% буюу 1180 нь эрэгтэй ажилчид байгаа нь хүйсийн тэнцвэртэй байдлыг харуулж байна.

2018 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.2 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.7 хувиар буюу 296.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Активын өсөлтийн 74.1 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 50.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлжээ.

Хүснэгт 4 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/


Үзүүлэлтүүд	2017-III	2018-III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	906.0	1,202.0	32.7%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	3.2%	3.9%	0.6%
Нийт өөрийн хөрөнгө	716.8	932.0	30.0%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	22.9%	30.1%	7.1%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	575.8	725.6	26.0%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	88.0%	90.5%	2.5%
Нийт зээл	592.4	811.6	37.0%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	4.4%	5.0%	0.6%
Нийт орлого	138.6	183.9	32.7%
Нийт зарлага	94.9	110.4	16.3%
Цэвэр ашиг	43.7	73.5	68.3%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 32.7 хувиар буюу 45.3 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 16.3 хувиар буюу 15.5 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 68.3 хувиар буюу 29.82 тэрбум төгрөгөөр өссөн байна.

• Програм ашиглалт

2018 оны III улирлын байдлаар 540 ББСБ-ын 328 нь буюу 60.7% нь үйл ажиллагаандаа санхүүгийн програм ашиглаж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 464 ББСБ-ын 293 нь буюу 63%, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 76 ББСБ-ын 46% нь санхүүгийн програмтай байна.

Зураг 3 Санхүүгийн програм ашиглалт




Нийт ББСБ-уудын 63.7% нь “Ай Би Ай” ХХК-ийн Спинел болон Даймонд програм, “Грейпсити” ХХК-ийн Ачидбанкир болон MARS програмуудыг ашиглаж байна.

- **Тархалт**

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.9% буюу 464 ББСБ, салбаруудын 71% буюу 146 салбар байршиж байна. Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 66.2% буюу 307 ББСБ Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Налайх болон Багануур дүүрэгт тус тус 1 ББСБ, нийт 6 салбар, Багахангай дүүрэгт банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Зураг 4 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт



Нийт 4 ББСБ-ын 5 төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаа ба Улаанбаатар хотын Багануур, Баянгол болон Сонгинохайрхан дүүрэг, Булган аймгийн Булган сум болон Америкийн Нэгдсэн улсын Вашингтон хотод тус тус байршиж байна.

Хүснэгт 5 ББСБ-уудын тархалт /хот/

Дүүрэг	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Сүхбаатар	162	18	180	29.5%
Чингэлтэй	145	23	168	27.5%
Баянгол	69	33	102	16.7%
Баянзүрх	48	40	88	14.4%
Хан-Уул	29	12	41	6.7%
Сонгинохайрхан	9	14	23	3.8%
Багануур	1	4	5	0.8%
Налайх	1	2	3	0.5%
Багахангай	0	0	0	0.0%
НИЙТ	464	146	610	100.0%

Орон нутагт нийт ББСБ-ын 14.1% буюу 76 ББСБ, салбаруудын 29.1% буюу 60 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 6 ББСБ-уудын тархалт /орон нутаг, бүсээр/

Бүс	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Хангайн бүс	25	23	48	35.3%
Төвийн бүс	22	15	37	27.2%
Зүүн бүс	14	9	23	16.9%
Баруун бүс	10	6	16	11.8%
Говийн бүс	5	7	12	8.8%
НИЙТ	76	60	136	100.0%

Нийт 63 ББСБ-ын 206 салбар бүртгэлтэй байгаа ба үүнээс 10-аас дээш салбартай 5 ББСБ-ын 68 салбар, 6-9 салбартай 6 ББСБ-ын 49 салбар, 2-5 салбартай 21 ББСБ-ын 58 салбар, 1 салбартай 31 ББСБ-ын 31 салбар Улаанбаатар хотын 8 дүүрэг, Монгол улсын 15 аймагт үйл ажиллагаа явуулж байна.

2. АКТИВЫН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт

2018 оны III улиралд ББСБ-уудын актив 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 32.7% буюу 295.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 24.0% буюу 232.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 7 Активын бүтэц /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2017-III дүн	2017-IV дүн	2018-III дүн	Өөрчлөлт			
				өмнөх оны мөн үе		оны эхэн	
				дүн	хувь	дүн	хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	868,820.25	932,691.58	1,155,366.72	286,546.47	33.0%	222,675.14	23.9%
Мөнгөн хөрөнгө	247,767.02	264,057.75	298,877.04	51,110.02	20.6%	34,819.29	13.2%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	4,347.75	2,742.65	1,479.00	-2,868.75	-66.0%	-1,263.65	-46.1%
Зээл (цэврээр)	539,038.54	582,002.00	748,230.46	209,191.92	38.8%	166,228.46	28.6%
Нийт зээл	592,409.73	638,007.83	811,600.69	219,190.95	37.0%	173,592.86	27.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	53,371.19	56,005.83	63,370.22	9,999.04	18.7%	7,364.39	13.1%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	-	125	232.74	232.74	-	107.74	86.2%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	5,923.36	8,110.65	9,614.25	3,690.89	62.3%	1,503.60	18.5%
Бусад хөрөнгө	71,743.58	75,653.52	96,933.23	25,189.65	35.1%	21,279.71	28.1%
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	37,160.57	36,487.42	46,608.75	9,448.18	25.4%	10,121.33	27.7%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	37,160.57	36,487.42	46,608.75	9,448.18	25.4%	10,121.33	27.7%
Нийт хөрөнгийн дүн	905,980.82	969,179.00	1,201,975.47	295,994.65	32.7%	232,796.47	24.0%

Салбарын нийт активын 96.1 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгө оны эхнээс 23.9% буюу 222.7 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 33.0% буюу 286.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт активын 87.1% буюу 1,047.1 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө болон цэвр зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 38 ББСБ нийт активын 43.7 хувийг, 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 367 ББСБ нийт активын 52.5 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 135 ББСБ нийт активын 3.8 хувийг эзэлж байна.

Активын гол өөрчлөлтүүдийг харвал цэвр зээлийн үлдэгдэл оны эхнээс 28.6% буюу 166.2 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 38.8% буюу 209.2 тэрбум

төгрөгөөр, мөнгөн хөрөнгө оны эхнээс 13.2% буюу 34.8 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 20.6% буюу 51.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 8 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/


Интервал	ББСБ тоо	Дүн	Эзлэх хувь
1 тэрбумаас доош	135	45.73	3.8%
1-4.9 тэрбум хүртэл	367	631.33	52.5%
5 тэрбум ба түүнээс дээш	38	524.92	43.7%
НИЙТ	540	1,201.98	100.0%

• Мөнгөн хөрөнгө

Нийт активын 24.9% буюу 298.9 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Үүнээс 164.7 тэрбум төгрөг бэлэн мөнгө хэлбэрээр, 90.1 тэрбум төгрөг нь харилцах дансанд, 75 ББСБ-ын 44.1 тэрбум төгрөг нь банк санхүүгийн байгууллагын хадгаламжид байршиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэлэн мөнгө 2.0 хувиар, хадгаламж 2.4 хувиар буурсан бол

тухайн ББСБ-ын харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө 4.5 хувиар өссөн байна.


Зураг 5 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /сүүлийн 5 жилээр/



• **Богино хугацаат хөрөнгө оруулалт**

2018 оны III улирлын байдлаар богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.1 хувийг бүрдүүлж байна. 20 ББСБ 1.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүний 89.5% буюу 1.3 тэрбум төгрөгийг 4 ББСБ-ын хөрөнгө оруулалт, 9.8% буюу 144.6 сая төгрөгийг 5 ББСБ-ын хөрөнгө оруулалт, 0.7 хувийг 10 ББСБ-ын тус бүр 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.


Зураг 6 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/



Цэвэр богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн өмнөх оны мөн үеэс 66.0% буюу 2.9 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ.

Арилжааны үнэт цаасанд нийт богино хугацаат хөрөнгө оруулалтын 47.7% буюу 704.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 52.3% буюу 774.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Зураг 7 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалтын 92.8 хувийг хувьцаагаарх, 3.6 хувийг Засгийн газрын бондоорх, 2.2 хувийг бусад хөрөнгө оруулалт, 1.3 хувийг өрийн бичгээрх хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.


• **Факторингийн тооцооны авлага, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, бусад хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө**

1 ББСБ ХХК-ийн факторингийн тооцооны авлага 232.8 сая төгрөгийн хэвийн үлдэгдэлтэй байна.

Өмчлөх бусад хөрөнгө өмнөх оны мөн үеэс 300.3 сая төгрөгөөр өсөж 1.5 тэрбум төгрөгт, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө 3.9 тэрбум төгрөгөөр өсөж 10.9 тэрбум төгрөгт хүрч тэдгээрт нийт 2.8 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Бусад хөрөнгө өмнөх оны мөн үеэс 35.1% буюу 25.2 тэрбум төгрөгөөр өсөж 96.9 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 8.1 хувийг бүрдүүлж байна. 2018 оны III улирлын байдлаарх бусад хөрөнгийн 49.9 хувийг хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 21.5 хувийг цэвэр авлага, 28.6 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Зураг 8 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



2018 оны III улирлын байдлаар чанаргүй авлага 375.7 сая төгрөг байгаа ба үүний 88.7%-д буюу 333.3 сая төгрөгийн авлагын эрсдэлийн сан байгуулсан байна.

Хүснэгт 9 Авлага /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 III	2018 III	Өөрчлөлт		Нийт авлагад эзлэх хувь
			Дүн	Хувь	
Нийт авлага	18.1	21.1	3.0	16.6%	100%
(Авлагын эрсдэлийн сан)	1.2	0.3	(0.9)	-72.3%	1.6%
Хэвийн	16.4	20.3	3.9	23.5%	95.9%
Хугацаа хэтэрсэн	0.5	0.5	0.0	3.9%	2.4%
Чанаргүй:	1.2	0.4	(0.9)	-69.8%	1.8%
Хэвийн бус	0.0	0.0	(0.0)	-88.2%	0.0%
Эргэлзээтэй	0.2	0.0	(0.2)	-99.8%	0.0%
Муу	1.0	0.4	(0.6)	-63.4%	1.8%
Нийт авлага (төгрөгийн)	15.9	17.7	1.8	11.5%	83.9%
Нийт авлага (валютын)	2.2	3.4	1.2	53.2%	16.1%

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 540 ББСБ-ын 57.0 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд 10.3 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 10 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 III	2018 III	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Үндсэн ба биет бус хөрөнгө	45.6	57.0	11.3	24.9%
Барилга байгууламж	16.5	21.0	4.5	27.1%
Техник хэрэгсэл	15.2	20.4	5.2	34.0%
Тавилга эд хогшил	6.0	7.2	1.1	19.0%
Дуусаагүй барилга	3.6	3.8	0.1	4.1%
Биет бус хөрөнгө	4.3	4.7	0.4	9.6%
Хуримтлагдсан элэгдэл	8.5	10.3	1.9	22.4%
Барилга байгууламжийн	1.1	1.5	0.3	28.5%
Техник хэрэгслийн	5.3	6.4	1.1	20.7%
Тавилга эд хогшлын	2.0	2.5	0.5	23.3%
ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	37.2	46.6	9.4	25.4%

2.2 Зээл


2018 оны III улирлын байдлаар 491 ББСБ 217,623 зээлдэгчдийн 811.6 тэрбум

төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь нийт активын 67.5 хувийг бүрдүүлж байна.

2.2.1 Зээлийн зориулалт

2017 оны жилийн эцэст 482 ББСБ 637.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан ба 2018 оны III улирлын байдлаар 434 ББСБ нийт 852.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бол 451 ББСБ-ын 677.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 2018 оны III улирлын байдлаар 470 ББСБ-ын 811.6 тэрбум төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэлтэй гарчээ.

Зураг 9 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/



Олгосон зээлийн 84.8% буюу 722.4 тэрбум төгрөгийг иргэдэд олгосон бол 15.2% буюу 129.9 тэрбум төгрөгийг хуулийн этгээдэд олгосон бол төлөгдсөн зээлийн 84.4% буюу 571.4 тэрбум төгрөг нь иргэдээс, 15.6% буюу 105.9 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс төлөгдсөн байна.

Олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл, хэрэглээний зээлд 451.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 359.6 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн, худалдааны салбарт 154.7 тэрбум төгрөгийн зээл олгож, 133.7 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгджээ.

Зураг 10 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/



2.2.2 Зээлийн багцын чанар


Хүснэгт 11 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн чанарын ангилал	2017 III дүн	2017 IV дүн	2018 III дүн	Өөрчлөлт	
				оны эхэн хувь	өмнөх оны мөн үе хувь
Хэвийн	473.4	527.0	690.4	31.0%	45.8%
Хугацаа хэтэрсэн	34.3	9.9	35.6	18.9%	3.7%
Чанаргүй:	84.7	81.1	85.7	5.6%	1.1%
Хэвийн бус	14.6	17.6	17.9	1.8%	22.8%
Эргэлзээтэй	18.6	14.2	19.3	36.1%	4.2%
Муу	51.6	49.3	48.4	-1.8%	-6.1%
(Зээлийн эрсдэлийн сан)	(53.4)	(56.0)	(63.4)	13.2%	18.7%
Нийт зээл	592.4	638.0	811.6	27.2%	37.0%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	539.0	582.0	748.2	28.6%	38.8%
Нийт зээл (төгрөгийн)	558.9	605.3	788.3	30.2%	41.1%
Нийт зээл (валютын)	33.5	32.7	23.3	-28.8%	-30.5%

2018 оны III улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдэл 811.6 тэрбум төгрөг байна. Үүнээс 690.4 тэрбум төгрөг буюу 85.1 хувийг хэвийн зээл, 35.6 тэрбум төгрөг буюу 4.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 85.7 тэрбум төгрөг буюу 10.6 хувийг


чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 52.3%-д эрсдэлийн сан байгуулсан байна.

Зураг 11 Зээлийн чанар (нийт зээлд эзлэх хувь)



Нийт зээлд эзлэх чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ харгалзан өмнөх оны мөн үеэс 3.7, 1.4 пунктээр буурсан бол хэвийн зээл 45.8% буюу 216.9 тэрбум төгрөгөөр өсөж нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.1 пунктээр өссөн байна.

Зураг 12 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа



Нийт зээлийн эцсийн үлдэгдэлд эзлэх валютын зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 пунктээр буурсан, төгрөгийн зээлийн хэмжээ 2.8 пунктээр өссөн дүнтэй гарчээ.

2.2.3 Зээлдэгчид

Хүснэгт 12 Ерөнхий статистик /харилцагчид/


Харилцагчдын мэдээлэл	Дүн	Хувь
Нийт харилцагчдын тоо	1,510,982	100.0%
Үүнээс: Эмэгтэй	734,675	48.6%
Хуулийн этгээд	2,628	0.2%
Зээлдэгчдийн тоо	217,623	100.0%
Хэвийн	200,373	92.1%
Хугацаа хэтэрсэн	8,367	3.8%
Чанаргүй:	8,883	4.1%
Хэвийн бус	2,681	1.2%
Эргэлзээтэй	2,648	1.2%
Муу	3,554	1.6%
Зээлдэгчдийн насжилт	216,606	100.0%
18-35 насны	110,959	51.2%
36-45 насны	61,601	28.4%
46-55 насны	32,349	14.9%
55-аас дээш	11,697	5.4%
Зээлдэгчдийн боловсрол	216,606	100.0%
-Дээд	127,842	59.0%
-Тусгай дунд	18,349	8.5%
-Бүрэн дунд	53,206	24.6%
-Дунд	15,751	7.3%
-Бага	1,458	0.7%

2018 оны III улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 491 ББСБ-ын 217,623 зээлдэгч бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өссөн үзүүлэлт бөгөөд энэ өсөлтийн 60.5 хувийг ХК-ийн зээлдэгчид бүрдүүлж байна.

Тэдгээрийн 92.1% буюу 200,373 нь хэвийн, 3.8% буюу 8,367 хугацаа хэтэрсэн, 1.2% буюу 2,681 нь хэвийн бус, 1.2% буюу 2,648 нь эргэлзээтэй, 1.6% буюу 3,554 муу зээлдэгчид байна.

Насжилтын хувьд авч үзвэл нийт зээлдэгчдийн 79.7% буюу 172,560 нь 18-45 насны, 14.9% буюу 32,349 нь 46-55 насны, 5.4% буюу 11,697 нь 55-аас дээш насны иргэд байна.

Зураг 13 Зээлдэгчдийн боловсрол




Боловсролын түвшингөөр дээд болон тусгай дунд боловсролтой иргэд нийт зээлдэгчдийн 146,191 буюу 67.5 хувийг бүрдүүлж байгаа бол бүрэн дунд боловсролтой иргэд 53,206 буюу 24.6 хувийг, бага болон дунд боловсролтой иргэд 17,209 буюу 7.9 хувийг бүрдүүлж байна.

2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү

2018 оны III улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 491 ББСБ-аас 434 ББСБ нийт 852.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн дээд хүү 10.0%, доод хүү 1.0%, жигнэсэн дундаж хүү 3.3% байна.

ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3%-тай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр буусан үзүүлэлт юм. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.8 пунктээр өндөр байна.

Зураг 14 Зээлийн жигнэсэн дундаж хүү



3. ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ

Салбарын нийт хөрөнгийн 22.5% буюу 270.0 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 77.5% буюу 932.0 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

2018 оны III улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 13 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/

Хөрөнгө	2017-II	2017-IV	2018-II	Өөрчлөлт			
				Өмнөх оны мөн үеэс		Оны эхнээс	
				Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
Өр төлбөр	189,142.9	211,011.1	270,020.3	80,877.4	42.8%	59,009.2	28.0%
Санхүүгийн эх үүсвэр	35,616.7	39,217.7	48,750.8	13,134.1	36.9%	9,533.1	24.3%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	104,913.6	112,761.7	135,550.2	30,636.6	29.2%	22,788.5	20.2%
Бусад эх үүсвэр	3,681.6	6,711.2	9,405.6	5,724.0	155.5%	2,694.4	40.1%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	4,458.4	6,876.9	21,079.8	16,621.3	372.8%	14,202.9	206.5%
Төслийн зээлийн санхүүжилт	15,926.3	14,869.9	16,893.4	967.1	6.1%	2,023.5	13.6%
Бусад өр төлбөр	24,546.2	30,573.7	38,340.5	13,794.3	56.2%	7,766.8	25.4%
Эздийн өмч	716,838.0	758,167.9	931,955.2	215,117.2	30.0%	173,787.3	22.9%
Хувьцаат капитал	575,821.1	595,389.1	725,563.5	149,742.4	26.0%	130,174.4	21.9%
Бусад өмч	6,577.3	6,570.8	9,202.9	2,625.6	39.9%	2,632.1	40.1%
Сангууд	419.0	429.6	587.0	168.0	40.1%	157.4	36.6%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	133,314.0	155,071.8	195,635.3	62,321.3	46.7%	40,563.5	26.2%
Хоёрдогч өглөг	706.6	706.6	966.6	260.0	36.8%	260.0	36.8%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	905,980.8	969,179.0	1,201,975.5	295,994.7	32.7%	232,796.5	24.0%

3.1 Өр төлбөр

ББСБ-ын өр төлбөрийн хэмжээ 2018 оны III улиралд өмнөх оны мөн үеэс 80.9 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар, оны эхнээс 59.0 тэрбум төгрөгөөр буюу 28.0 хувиар өсөж нийт өр төлбөрийн хэмжээ 270.0 тэрбум төгрөг хүрсэн нь пассивын өсөлтийн 27.3 хувийг бүрдүүлж байна.


- **Итгэлцлийн үйлчилгээний өглөг**

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 29 ББСБ-ын 23 нь 48.8 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт пассивын 4.1 хувьтай тэнцэж байна.

13 ББСБ 1 тэрбум төгрөг хүртэлх дүнгээр 4.5 тэрбум төгрөгийн, 10 ББСБ 1 тэрбум төгрөгөөс дээш дүнгээр 44.2 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн 48.8 тэрбум төгрөгийн 81.4% буюу 39.7 тэрбум төгрөгийг 22 ББСБ төгрөгөөр, 18.6% буюу 9.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 10 ББСБ валютаар татан төвлөрүүлсэн байна.

Зураг 15 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



- Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2018 оны III улирлын байдлаар 75 ББСБ дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагын 135.6 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт хөрөнгийн 11.3 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 30.6 тэрбум төгрөгөөр буюу 29.2 хувиар, оны эхнээс 22.8 тэрбум төгрөгөөр буюу 20.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 14 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

Авсан зээлийн хэмжээ	ББСБ тоо	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн хэмжээ
1 тэрбумаас дээш	18	84.9%	73.9
0.1-0.9 тэрбум	37	14.0%	12.2
0.1 тэрбумаас доош	18	1.0%	0.9
НИЙТ	73	100.0%	87.0

Хүснэгт 15 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

Авсан зээлийн хэмжээ	ББСБ тоо	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн хэмжээ
10 тэрбумаас дээш	1	71.4%	32.5
1-9 тэрбум	2	25.9%	11.8
1 тэрбумаас доош	3	2.7%	1.2
НИЙТ	6	100.0%	45.6


Банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн 64.2 хувийг дотоодын, 33.6 хувийг гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, 2.2 хувийг дотоодын банк санхүүгийн байгууллагаас авсан хугацаа хэтэрсэн 2 ББСБ-ын 2.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас 73 ББСБ 87.0 тэрбум төгрөг, гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас 6 ББСБ 45.6 тэрбум төгрөгийн зээл татан төвлөрүүлсэн байна.

- Бусад эх үүсвэр

Бусад эх үүсвэр нийт пассивын 0.8% буюу 9.4 тэрбум төгрөгийг бүрдүүлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 1.6 дахин буюу 5.7 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 40.1% буюу 2.7 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ. Бусад эх үүсвэрийн 64.5% нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг, 35.5% нь

төлбөр тооцооны үйлчилгээний өглөг байна.

Зураг 16 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/



2018 оны III улирлын байдлаар цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 23 ББСБ-аас 9 ББСБ нь 6.1 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрөлтэй 3 ББСБ-аас 1 ББСБ нь төлбөр тооцооны үйлчилгээний 3.3 тэрбум төгрөгийн өглөгтэй гарчээ.

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн 93.5 хувийг 3 ББСБ-ийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бол төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийг 1 ББСБ-ийн үлдэгдэл бүрдүүлж байна.

- ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2018 оны III улирлын байдлаар 18 ББСБ 21.1 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан нь өмнөх оны мөн үеэс 4.7 дахин буюу 16.6 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 3.1 дахин буюу 14.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны мөн үеэс 4.7 дахин өссөн өсөлтөд 12 ББСБ 16.2 тэрбум төгрөгийн өрийн бичгээр хөрөнгө оруулалт татсан нь нөлөөлсөн байна.


- Төслийн зээл санхүүжилт

2018 оны III улиралд 36 ББСБ 16.9 тэрбум төгрөгийн төслийн зээлтэй байгаа нь нийт

хөрөнгийн 1.4 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 6.1% буюу 967.1 сая төгрөгөөр, оны эхнээс 13.6% буюу 2.0 тэрбум төгрөгөөр өсжээ.

Төслийн санхүүжилтийн 96.2% буюу 16.3 тэрбум төгрөгийг төгрөгийн, 3.8% буюу 0.6 тэрбум төгрөгийг валютын санхүүжилт бүрдүүлж байна.

Зураг 17 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/




Богино хугацаат санхүүжилтээр 9 ББСБ 3.3 тэрбум төгрөг, урт хугацаат санхүүжилтээр 29 ББСБ 13.6 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна.

Төслийн зээлийн 46% буюу 7.7 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас, 37% буюу 6.3 тэрбум төгрөгийг гадаад байгууллагаас, 12% буюу 2.1 тэрбум төгрөгийг бусад санхүүжилтээс, 5% буюу 838.3 сая төгрөгийг Засгийн газрын төслийн зээлийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

• Бусад өр төлбөр

Зураг 18 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг /сая төгрөгөөр/



2018 оны III улирлын байдлаар 473 ББСБ 38.3 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт пассивын 3.2

хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 56.2% буюу 13.8 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 25.4% буюу 7.8 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм.

Бусад өр төлбөрийн 81.9% буюу 31.4 тэрбум төгрөгийг бусад пассив, 18.1% буюу 6.9 тэрбум төгрөгийг хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг бүрдүүлж байна.

Бусад пассивын задаргаа:

Хүснэгт 16 Бусад пассив /сая төгрөгөөр/


Төрөл	2018-III Дүн	Эзлэх хувь
БУСАД ПАССИВ	31,405.5	100%
Бусад өглөг	22,338.0	71.1%
Татварын өглөг	5,638.2	18.0%
Ногдол ашгийн өглөг	2,052.6	6.5%
Салбар хоорондын тооцооны өглөг	926.8	3.0%
Цалингийн өглөг	225.6	0.7%
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	201.9	0.6%
Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өглөг	22.4	0.1%

3.2 Өөрийн хөрөнгө

2018 оны III улирлын байдлаар ББСБ-уудын пассив 32.7% буюу 296.0 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 72.7 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

2018 оны III улирлын байдлаар өөрийн хөрөнгийн 77.9% буюу 725.6 тэрбум төгрөг нь хувь нийлүүлсэн хөрөнгө, 21.0% буюу 195.6 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг, 1.0% буюу 9.2 тэрбум төгрөгийг бусад өмч, 0.1% буюу 1.0 тэрбум төгрөгийг хоёрдогч өглөг, 0.06% буюу 0.6 тэрбум төгрөгийг сангууд бүрдүүлж байна.

Зураг 19 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



3.3 Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт

2018 оны III улирлын байдлаар 286 ББСБ 113.0 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгө /цаашид “ХНХ” гэх/-өө нэмэгдүүлсэн ба зөвхөн III улиралд үйл ажиллагаа эрхэлж буй 29 ББСБ 14.6 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн ба биелэлт 95.0%-тай байна.

ББСБ-уудын ХНХ-өө нэмэгдүүлж буй явц 2018 оны III улирлын байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 17 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Улаанбаатар хот/

Огноо	Улаанбаатар хот			Эзлэх хувь	
	Интервал /тэрбум төгрөг/	ХНХ	ББСБ тоо	Дүн	Тоо
2018.02.10	1.0 -1.3	283.7	277	40.5%	59.7%
2019.02.10	1.4-1.8	51.1	33	7.3%	7.1%
2020.02.10	1.9-2.4	67.4	32	9.6%	6.9%
2021.02.10	2.5-аас дээш	281.9	70	40.2%	15.1%
Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг		10.7	43	1.5%	9.3%
1.0 тэрбум хүргэх шаардлага хангаагүй		5.9	9	0.8%	1.9%
НИЙТ		700.7	464	100%	100%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 464 ББСБ-аас 9 ББСБ ХНХ-ийн доод хэмжээг хангаж ажиллаагүй ба үүнээс 4 ББСБ-ын үйл ажиллагааг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн, 3 ББСБ материалаа хугацаа хоцорч ирүүлсэн байгаа бол 2 ББСБ Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга болон гадаад валют арилжааны ББСБ байна.

Хүснэгт 18 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сум/

Огноо	Дархан хот, Эрдэнэт хот			Эзлэх хувь	
	Интервал /сая.төг/	ХНХ	ББСБ тоо	Дүн	Тоо
2018.02.10	250.0-349.9	1.3	5	12.0%	41.7%
2019.02.10	350.0-474.9	1.2	3	11.1%	25.0%
2020.02.10	475.0-599.9	0.6	1	5.6%	8.3%
2021.02.10	600.0-аас дээш	7.7	3	71.3%	25.0%
НИЙТ		10.8	12	100%	100%

Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад үйл ажиллагаа эрхэлж буй 12 ББСБ ХНХ-ийн доод хэмжээг бүрэн хангаж ажилласан байна.

Хүснэгт 19 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Бусад аймаг, сумдад/


Огноо	Бусад аймаг, сумдад			Эзлэх хувь	
	Интервал /сая төгрөг/	ХНХ	ББСБ тоо	Дүн	Тоо
2018.02.10	70.0-99.9	1.6	22	11.4%	34.4%
2019.02.10	100.0-144.9	0.8	7	5.7%	10.9%
2020.02.10	145.0-199.9	0.3	2	2.2%	3.1%
2021.02.10	200.0-аас дээш	10.5	22	75.0%	34.4%
Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг		0.4	3	3	-
1.0 тэрбум хүргэх шаардлага хангаагүй		0.4	8	8	12.5%
НИЙТ		14.0	64	64	100.0%

Бусад аймаг, сумдад үйл ажиллагаа эрхэлж буй 64 ББСБ-аас 8 ББСБ ХНХ-ийн доод хэмжээг хангаж ажиллаагүй ба үүнээс 4 ББСБ-ын үйл ажиллагааг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн бол 4 ББСБ материалаа хугацаа хоцорч ирүүлсэн байна.

4. ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 183.9 тэрбум төгрөгийн орлого олж, 110.4 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 73.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Зураг 20 Ашигт ажиллагааны үзүүлэлт



4.1 Орлого

2018 оны III улирлын байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.7% буюу 45.3 тэрбум төгрөгөөр өсч 183,921.5 сая төгрөгт хүрчээ. Өмнөх оны мөн үеэс хүүгийн орлого 35.4% буюу 40.6 тэрбум төгрөгөөр, хүүгийн бус орлого 14.3% буюу 2.8 тэрбум төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлого 44.5% буюу 1.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 21 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/



• Хүүгийн орлого

Хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.4 хувиар буюу 40.6 тэрбум төгрөгөөр өсөж 155.5 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт орлогын 84.5 хувийг бүрдүүлж байна.


479 ББСБ 155.5 тэрбум төгрөгийн хүүгийн орлогын дүнтэй гарсан байна.

Хүүгийн орлогыг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн 149.6 тэрбум төгрөгийн орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн 6.3 тэрбум төгрөгийн орлого, үнэт цаасны хүүгийн 236.1 сая төгрөгийн орлого, 0.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлогын буцаалт /сөрөг утгатай/ бүрдүүлж байна.

• Хүүгийн бус орлого

Хүүгийн бус орлого нь 2018 оны III улирлын байдлаар нийт орлогын 12.2% буюу 22.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 14.3% буюу 2.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

Зураг 22 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/



Гадаад валют арилжааны орлого 292.5 сая төгрөгөөр буурч 3.1 тэрбумд хүрсэн бол гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого 3.8 тэрбум төгрөгөөр буурч 5.2 тэрбум төгрөг, санхүүгийн үйлчилгээний орлого 81.0% буюу 6.3 тэрбум төгрөгөөр өсч 14.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Санхүүгийн үйлчилгээний орлогын өсөлтийн 78.2 хувийг үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого, 14.7 хувийг бусад орлого, 6.9 хувийг мөнгөн гуйвуулгын орлогын өсөлт бүрүүлж байна.

Хүснэгт 20 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая төгрөгөөр/

Санхүүгийн үйлчилгээний орлого	2017 III	2018 III	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	2.8	2.82	-
Мөнгөн гуйвуулгын орлого	564.3	1,001.4	437.0	77.4%
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	110.5	117.3	6.7	6.1%
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	4,092.4	9,021.4	4,929.0	2.2 дахин
Бусад	3,016.0	3,943.2	927.2	30.7%
НИЙТ	7,783.2	14,086.1	6,302.8	81.0%

- **Үндсэн бус үйл ажиллагааны орлого**

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогын 3.3 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 тэрбум төгрөг буюу 44.5 хувиар өсчээ.

Зураг 23 Үндсэн бус үйл ажиллагааны орлого



4.2 Зарлага

2018 оны III улиралд 110.4 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.3 хувиар өссөн үзүүлэлт байна.

Хүснэгт 21 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2017 III	2018 III	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Хүүгийн зардал	10.7	14.4	3.7	35.0%
Хүүгийн бус зардал	58.7	67.1	8.4	14.3%
Болзошгүй эрсдэлийн зардал	18.4	17.8	-0.6	-3.4%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1.1	2.3	1.1	99.8%
Орлогын албан татварын зардал	6.0	8.9	2.9	47.8%
Нийт зарлага	94.9	110.4	15.5	16.3%

Үндсэн бус үйл ажиллагааны зардал 99.8% буюу 15.5 тэрбум төгрөгөөр, орлогын албан татварын зардал 47.8% буюу 2.9 тэрбум төгрөгөөр, хүүгийн зардал 35.0% буюу 3.7

тэрбум төгрөгөөр, хүүгийн бус зардал 14.3% буюу 8.4 тэрбум төгрөгөөр өссөн бол болзошгүй эрсдэлийн зардал 3.4% буюу 633.7 сая төгрөгөөр буурчээ.

- **Хүүгийн зардал**

Хүүгийн зардал нийт зардлын 13.1% буюу 14.4 тэрбум төгрөг байна. 2017 оны мөн үеийн дүнтэй харьцуулахад 35.0% буюу 3.7 тэрбумаар өссөн байна.

- **Хүүгийн бус зардал**

Хүүгийн бус зардал нь 67.1 тэрбум төгрөг буюу нийт зардлын 60.7 хувийг бүрдүүлж байна. 2017 оны мөн үетэй харьцуулахад 14.3% буюу 8.4 тэрбум төгрөгөөр өсжээ.

- **Болзошгүй эрсдэлийн зардал**

Нийт зардлын 16.1% буюу 17.9 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал бүрдүүлж байгаа ба энэ зардал нь өмнөх оны мөн үеэс 3.4% буюу 633.7 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарсан байна.

- **Үндсэн бус үйл ажиллагааны зардал**


Нийт зардлын 2.1 хувийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 99.8% буюу 1.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ.

4.3 Ашигт ажиллагаа

2018 оны III улиралд ББСБ-ууд 73.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 29.8 тэрбум төгрөгөөр буюу 68.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

2018 оны III улиралд 540 ББСБ-ын 443 нь буюу 82.0% нь оны эхнээс өссөн дүнгээр 79.2 тэрбум төгрөгийн ашигтай, 79 нь буюу 14.6% нь 5.7 тэрбум төгрөгийн алдагдалтай, 18 нь буюу 3.3% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Зураг 24 Ашигийн өсөлт /хувиар/




5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2018 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 540 ББСБ-ын 87.0% буюу 470 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 13.0% нь буюу 70 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 51 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 13 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 5 ба түүнээс дээш зохистой харьцаа алдагдсан 1 ББСБ байна.

Зураг 25 Зохистой харьцаа



5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 22 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	43	87.8%
1 зохистой харьцааг хангаагүй	2	4.1%
2 зохистой харьцааг хангаагүй	4	8.2%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
НИЙТ	49	100%

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй

байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 93.9%;

2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 45 ББСБ хангасан буюу биелэлт 91.8%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн хангасан;
5. Үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу 95.9%;
6. Өөрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Эдгээр 49 ББСБ-уудын хувьд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шалгуур үзүүлэлт хамгийн ихээр алдагдсан байна.

5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 23 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	381	86.4%
1 зохистой харьцааг хангаагүй	46	10.4%
2 зохистой харьцааг хангаагүй	9	2.0%
3 зохистой харьцааг хангаагүй	3	0.7%
4 зохистой харьцааг хангаагүй	1	0.2%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	1	0.2%
НИЙТ	441	100%

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн

- активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 433 ББСБ хангасан буюу биелэлт 98.2%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 433 ББСБ хангасан буюу биелэлт 98.2%;
 3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 439 ББСБ хангасан буюу биелэлт 99.5%;
 4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 427 ББСБ хангасан буюу биелэлт 96.8 хувь;
 5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний зөрүү 0 байх шаардлагыг бүрэн хангасан;
 6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 427 ББСБ хангасан буюу биелэлт 96.8%;
 7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 436 ББСБ хангасан буюу биелэлт 98.9%;
 8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 436 ББСБ хангасан буюу биелэлт 98.9%;
 9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 10. Нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
 11. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага 440 ББСБ хангасан буюу биелэлт 99.8%;

12. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага 430 ББСБ хангасан буюу биелэлт 97.5%;

13. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 427 ББСБ хангасан буюу биелэлт 96.8% хувь;

14. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх 441 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа үзүүлэлтүүдийг 8-14 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 24 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	46	92.0%
1 зохистой харьцааг хангаагүй	3	6.0%
2 зохистой харьцааг хангаагүй	0	0%
3 зохистой харьцааг хангаагүй	1	2.0%
4 зохистой харьцааг хангаагүй	0	0%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	0	0%
НИЙТ	50	100%

Журмын 3.4-т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;

2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
 3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
 4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
 5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг хангасан байх шаардлага бүрэн;
 6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 49 ББСБ хангасан буюу биелэлт 98.0%;
 7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 10 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 10. Худалдан авах хувьцааны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 49 ББСБ хангасан буюу биелэлт 98.0%;
 11. Нэг компаниас худалдан авах хувьцааны төвлөрлийн үзүүлэлт өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
 12. Өрийн бичгийн эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 14. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 15. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 96.0%;
 16. Итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 17. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 96.0%;
 18. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шаардлагыг бүрэн хангаж ажилласан байна.
- Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх 50 хуулийн этгээдийн хувьд гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 2 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд

- Ерөнхий статистик

Тайлант онд хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 76 ББСБ, 184 хувьцаа эзэмшигч, 192 ажилтан, 4 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 8,107 харилцагч, 6,392 зээлдэгчдэд хүрч ажиллаж байна.

Хамгийн олон ББСБ-тай аймгууд нь Төв аймаг 11, Дорнод аймаг 8, Орхон аймагт 7 ББСБ тус тус байршиж байна.

Зураг 26 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт



Хүснэгт 25 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/

№	Үйл ажиллагааны төрөл	ББСБ тоо
1	Зээл	73
2	Гадаад валютын арилжаа	6
3	ХОСЧЗМӨ	2
4	Итгэлцлийн үйлчилгээ	1
НИЙТ		82

ББСБ-ын 4 төрлийн 82 тусгай зөвшөөрлийн хүрээнд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. 35 ББСБ буюу 46.1% нь санхүүгийн програмтай байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 94.8% буюу 6,060 нь хэвийн, 2.6% буюу 165 нь хугацаа хэтэрсэн, 2.6% буюу 167 нь чанаргүй зээлдэгчид байна.

ББСБ-уудын зээлдэгчдийн насжилтаар авч үзвэл орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт

зээлдэгчдийн 69.5 хувийг 18-45 насны, 22.5 хувийг 46-55 насны, 8.1 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлж байна. Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой иргэд 49.3%, тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой иргэд 42.4%, бага болон дунд боловсролтой иргэд 8.4 хувийг бүрдүүлж байна.

- **Актив**

Салбарын нийт активын 2.4 хувийг бүрдүүлж байгаа орон нутгийн ББСБ-уудын 29.4 тэрбум төгрөгийн актив хөрөнгийн 6.5 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 163.2 сая төгрөг нь богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/, 20.1 тэрбум нь зээл /цэврээр/, 129.6 тэрбум төгрөг нь өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр), 1.4 тэрбум төгрөгийг бусад хөрөнгө


бүрдүүлж байгаа ба үндсэн ба биет бус хөрөнгө цэврээр 1.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 26 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	28,283.2	96.2%
Мөнгөн хөрөнгө	6,488.7	22.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	163.2	0.6%
Нийт зээл	24,835.5	84.5%
(Зээлийн эрсдэлийн сан)	-4,765.8	-16.2%
Зээл (цэврээр)	20,069.7	68.3%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	-	-
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	129.6	0.4%
Бусад хөрөнгө	1,432.1	4.9%
Эргэлтийн бус хөрөнгө	1,109.6	3.8%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	1,109.6	3.8%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,473.7	5.0%
Нийт хөрөнгийн дүн	29,392.81	100.0%

Зээлийн хувьд 19.3 тэрбум төгрөгийн хэвийн зээл, 389.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 5.2 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Зээлийн эрсдэлийн санг хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 86.0%-д байгуулжээ.

Зураг 27 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



1.5 тэрбум төгрөгийн үндсэн (биет) ба биет бус хөрөнгөнд 364.1 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

- **Пассив**

Орон нутгийн 76 ББСБ-ын хөрөнгийн 91.6% буюу 26.9 тэрбум төгрөг нь эздийн өмч, 8.4% буюу 2.5 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. Орон нутгийн ББСБ-уудын

нийт хөрөнгийн 84.4 хувийг буюу 24.8 тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлж байгаа ба энэ нь салбарын хувьцаат капиталын 3.4 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 27 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум.төг/	Дүн	Хувь
Өр төлбөр	2.46	8.4%
Санхүүгийн эх үүсвэр	1.02	3.5%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	0.33	1.1%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.10	0.3%
Төслийн зээлийн санхүүжилт	0.67	2.3%
Бусад өр төлбөр	0.34	1.2%
Эздийн өмч	26.93	91.6%
Хувьцаат капитал	24.81	84.4%
Бусад өмч	0.33	1.1%
Сангууд	0.43	1.5%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	1.36	4.6%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	29.39	100.0%

- **Орлого үр дүнгийн тайлан**

2018 оны III улиралд орон нутгийн ББСБ-ууд 4.8 тэрбум төгрөгийн орлоготой, 2.5 тэрбум төгрөгийн зарлагатай, 2.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа. Орлогын 92.2 хувийг хугацаандаа байгаа хүүгийн орлого бүрдүүлж байна. Нийт зардлын 73.5% буюу 1.9 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал, 9.7% буюу 244.8 сая төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал эзэлж байна.

6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Хүснэгт 28 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/

Үйл ажиллагааны төрөл	ББСБ-ын тоо
Зээл	28
Факторингийн үйлчилгээ	1
Төлбөрийн баталгаа гаргах	1
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	2
Гадаад валютын арилжаа	11
Итгэлцлийн үйлчилгээ	4
Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	1
НИЙТ	48

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай, 9 улсын, 69 хувьцаа

эзэмшигчийн 28 ББСБ, 26 салбар, 3 төлөөлөгчийн газар, 7 төрлийн 48 тусгай зөвшөөрлийн хүрээнд 282 ажилтантайгаар 24,649 харилцагч, 16,826 зээлдэгчдэд хүрч үйл ажиллагаа явуулж байна. 24 ББСБ буюу 85.7% нь үйл ажиллагаандаа санхүүгийн програм ашиглаж байна.

Үүнээс гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай 6 улсын, 17 хувьцаа эзэмшигчийн /үүнээс 8 хуулийн этгээд, 9 хувь хүн/ 14 ББСБ, хамтарсан хөрөнгө оруулалттай 6 улсын, 24 хувьцаа эзэмшигчийн /үүнээс 7 хуулийн этгээд, 14 хувь хүн/ 14 ББСБ байна.

- **Актив**

Гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ-ын хөрөнгө 146.8 тэрбум төгрөг нь нийт хөрөнгийн 12.2 хувийг бүрдүүлж байна.

Активын 102.0 тэрбум төгрөг нь цэвэр зээл, 26.3 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байгаа бол мөнгөн хөрөнгийн 6.8 тэрбум төгрөг нь кассанд, 13.6 тэрбум төгрөг нь харилцах дансанд, 5.8 тэрбум төгрөг нь хадгаламжийн дансанд тус тус байршиж байна.

- **Пассив**

Пассивын 48.0% буюу 67.8 тэрбум төгрөгийг өр төлбөр, 52.0% буюу 73.4 тэрбум төгрөгийг эздийн өмч эзэлж байна.

Хүснэгт 29 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	Дүн	Хувь
Өр төлбөр	70.4	47.9%
Санхүүгийн эх үүсвэр	8.4	5.7%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	47.8	32.6%
Бусад эх үүсвэр	3.7	2.5%
Төслийн зээлийн санхүүжилт	6.5	4.4%
Бусад өр төлбөр	4.0	2.7%
Эздийн өмч	76.5	52.1%
Хувьцаат капитал	63.4	43.1%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	11.9	8.1%
Эздийн өмчийн бусад хэсэг	1.2	0.8%
НИЙТ ПАССИВ	146.8	100.0%

Нийт 540 ББСБ-ын пассивын бүтэц нь эздийн өмч давамгайлсан бүтэцтэй байдаг бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд өр төлбөр болон эздийн өмчийн харьцаа ойролцоо дүнтэй байна. Өр төлбөрийн 68.0% нь дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл байгаа бол эздийн өмчийн 82.9% нь хувьцаат капитал байна.

Дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн 30.8% буюу 14.7 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагуудаас, 69.2% буюу 33.1 тэрбум төгрөгийг гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас авсан өр төлбөр эзэлж байна.

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ 24.5 тэрбум төгрөгийн орлоготой, 20.8 тэрбум төгрөгийн зарлагатай, 3.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа ББСБ-ууд нь нийт ББСБ-уудын 8.5%, гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудын 30.0% буюу 46 ББСБ, 6 салбар, 137 ажилтан, 41,004 харилцагчдад хүрч үйл ажиллагаа эрхэлж байна.

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 153 ББСБ байгаагаас дагнан эрхэлж байгаа 46 ББСБ-уудын 43 нь Улаанбаатар хотод, 3 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

- **Актив**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын нийт активын хэмжээ 12.0 тэрбум төгрөг байгаа нь салбарын активын 1.0% байна. Үйл ажиллагааны онцлогоос хамааран нийт активын 95.9% нь мөнгөн хөрөнгө, 0.01% нь богино хугацаат хөрөнгө оруулалт, 0.9% нь бусад хөрөнгө байгаа бөгөөд 1 ББСБ 1 сая

төгрөгийн засгийн газрын арилжааны үнэт цаас худалдаж авсан байна. 501.5 сая төгрөгийн үндсэн /биет/ ба биет бус хөрөнгөнд 118.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцжээ.

Хүснэгт 30 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	11,645,354.92	96.8%
Мөнгөн хөрөнгө	11,539,850.60	95.9%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,000.00	0.01%
Бусад хөрөнгө	104,504.32	0.9%
Эргэлтийн бус хөрөнгө	383,312.90	3.2%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	501,548.37	4.2%
(Хуримтлагдсан элэгдэл)	(118,235.47)	-1.0%
НИЙТ ХӨРӨНГӨ	12,028,667.82	100.0%

- **Пассив**

Нийт хөрөнгийн 92.3% буюу 11.1 тэрбум төгрөг нь хувьцаат капитал, 5.1% буюу 613.6 сая төгрөг нь хуримтлагдсан ашиг, 2.3% буюу 280.5 сая төгрөг нь өр төлбөр, 0.2% буюу 29.7 сая төгрөг нь бусад өмч байна.

Хүснэгт 31 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	155.7	1.3%
Бусад өр төлбөр	124.7	1.0%
Хувьцаат капитал	11,104.9	92.3%
Бусад өмч	29.7	0.2%
Хуримтлагдсан ашиг	613.6	5.1%
Нийт пассив	12,028.7	100.0%

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд 1,020.9 сая төгрөгийн орлоготой, 895.9 сая төгрөгийн зарлагатай, 125.1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

26 ББСБ 198.3 сая төгрөгийн цэвэр орлоготой, 17 ББСБ 73.2 сая төгрөгийн алдагдалтай, 3 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.


Хүснэгт 32 Орлогын бүтэц /мянган төгрөгөөр/

НИЙТ ОРЛОГО	1,020,946.82	100.0%
Хүүгийн орлого	9,865.39	1.0%
Хүүгийн бус орлого	1,006,859.63	98.6%
Гадаад валютын арилжааны орлого	882,452.17	86.4%
Хани болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	89,987.46	8.8%
Санхүүгийн үйлчилгээний орлого	34,420.00	3.4%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4,221.80	0.4%

Зарлагын бүтцийн хувьд 1.5% нь хүүгийн зардал, 95.1% нь хүүгийн бус зардал, 0.7% нь үндсэн бус үйл ажиллагааны зардал, 2.7% нь орлогын албан татварын зардал байна.

Хүүгийн бус зардлын бүтцийг авч үзвэл:

Зураг 28 Хүүгийн бус зардлын бүтэц



ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс: 2018 оны III улирлын байдлаар нийт 446 ББСБ 856.6 сая төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.
- Зээлийн мэдээллийн сан: Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 491 ББСБ-ын 82.2% буюу 444 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх: 2018 оны III улиралд Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 540 ББСБ-ын 81.5 хувь буюу 440 ББСБ хэрэгжүүлсэн байна.
- 20 сая төгрөгөөс дээш гүйлгээг мэдээлэх: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд нэр бүхий 190 ББСБ, 8,609 удаагийн тохиолдлоор, 668.1 тэрбум төгрөгийг /нэр бүхий 5 ББСБ 10 удаагийн 1,092.7 сая төгрөгийн сэжигтэй гүйлгээ, 189 ББСБ 8,599 удаагийн тохиолдлоор 667.1 тэрбум төгрөгийн 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээлэл/ Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

2018 оны III улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 540 ББСБ-аас 97.0% буюу 524 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 16 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2018 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 4766 хувь нийлүүлэгчдийн 540 ББСБ, 206 салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2652 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,510,982 харилцагчдад хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 464 ББСБ, 146 салбар Улаанбаатар хотод, 76 ББСБ, 60 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 оны III улиралд ББСБ-уудын актив 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 33.6% буюу 287.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 18.0% буюу 174.5 тэрбум төгрөгөөр өсөж банкны салбарын нийт активын 3.9 хувьтай тэнцэж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 367 ББСБ нийт активын 52.5 хувийг, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 38 ББСБ нийт активын 43.7 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 135 ББСБ нийт активын 3.8 хувийг бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 811.6 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 5.0 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 690.4 тэрбум төгрөг буюу 85.1 хувийг хэвийн зээл, 35.6 тэрбум төгрөг буюу 4.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 85.7 тэрбум төгрөг буюу 10.6 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 52.3%-д эрсдэлийн сан байгуулсан байна. Нийт зээлд эзлэх чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ харгалзан өмнөх оны мөн үеэс 3.7, 1.4 пунктээр буурсан бол хэвийн зээл 45.8% буюу 216.9 тэрбум төгрөгөөр өсөж нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.1 пунктээр өссөн байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 491 ББСБ-аас 434 ББСБ нийт 852.3 тэрбум төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгосон нь банкны салбартай харьцуулахад 1.8 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 22.5% буюу 270.0 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 77.5% буюу 932.0 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө байна. 2018 оны III улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 72 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 39.8 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.0-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 348 ББСБ 56.5 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 120 ББСБ 3.7 хувийг бүрдүүлж байна.

2018 оны III улирлын байдлаар 540 ББСБ 183.9 тэрбум төгрөгийн орлоготой, 110.4 тэрбум төгрөгийн зарлагатай 73.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Үүнээс ББСБ-ын 443 нь буюу 82.0% нь 79.2 тэрбум төгрөгийн ашигтай, 79 нь буюу 14.6% нь 5.7 тэрбум төгрөгийн алдагдалтай, 18 нь буюу 3.3% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна. Активын өгөөж 7.0%, өөрийн хөрөнгийн өгөөж 8.9%-тай байна.

Нийт ББСБ-ын 87.0% буюу 470 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 70 ББСБ буюу 13.0% нь зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР